

## МЭДЭЭЛЭЛ, ТЭМДЭГЛЭЛ

ЭНХИЙГ ЭРХЭМЛЭГЧ  
БУДДИСТУУДЫН ЧУУЛГА

(Азийн буддистуудын энх тайвны төлөө бага хурлын VII ерөнхий бага хурлаар АБЭТБХ-ын ерөнхийлөгчөөр Монголын буддистуудын төв Гандантэгчэнлин хийдийн тэргүүн хамба лам Х. Гаадан улиран сонгогдов. Буддистуудын энх тайвны хөдөлгөөн өргөжиж байгааг харгалзан АБЭТБХ-ын дэд ерөнхийлөгчийн тоог нэмэгдүүлэн тав болгож, дэд ерөнхийлөгчөөр Энэтхэгийн хутагт лам Кушок Бакула ренпоче, Японы их ламтан Шожун Мибу, Вьетнамын мэргэн ламтан Тич Мин Чау, Шри Ланкийн их ламтан М. Випуласара, Лаосын их ламтан Анантосоунтоне нарыг, ерөнхий нарийн бичгийн даргаар Монголын эрдэмтэн Г. Лув санцэрэнг тус тус сонгожээ. Хурлын тухай товч мэдээг дор нийтлэв. — редакц)

АБЭТБХ-ын VII Ерөнхий бага хурал БНАЛАУ-ын нийслэл Вьентьян хотноо «Энх тайван шударга ёс, хамаг амьтны тусын тулд мөргөл уншлага, үйл бүтээлээ зориулая!» гэсэн уриан дор 1986 оны 2 дугаар сарын 12—14-ний өдөр амжилттай болж өнгөрлөө.

Ерөнхий бага хуралд АБЭТБХ-ын үндэсний төвүүдээс 100 гаруй төлөөлөгч оролцлоо. Бага хуралд Бангладеш, Вьетнам, ЗХУ, Кампучи, Шри Ланка, Лаос, Монгол, БНАСАУ, Япон дахь Солонгос, Энэтхэг дэх төвдийн үндэсний төв, Далай ламын шашин, соёлын хэрэг эрхлэх зөвлөл, Афганистан, Бирма, Бутан, Польш, Унгарын буддистуудыг төлөөлөн зочид, ажиглагчид, мөн ЭУБ, ДЭТЗ, Христос шашинтны энх тайвны бага хурал, Дэлхийн олон шашинтны Москвагийн бага хурлын ажил үргэлжлүүлэх хороо, Европын католик шашинтны Берлингийн бага хурал, Дэлхийн сүм хийдийн зөвлөл, Дэлхийн Лютертний холбоо, ААЭСНБ, СУАЭХ, ДАЗХ, ОУСБ, Олон улсын Пугуашийн бага хурал болон Оросын үнэн алдарт шашинтан, Дунд Ази болон Казахстаны лалын шашинтны төв захиргаа зэрэг 20 шахам олон улсын байгууллага, үндэсний шашны болон энх тайвны байгууллага, хөдөлгөөнүүдийн зочид төлөөлөгчид оролцсон юм.

АБЭТБХ-ын VII Ерөнхий бага хуралд БНАЛАУ, ЗСБНХУ, БНСВУ, БНХАУ, БНМАУ, Энэтхэгийн төрийн ба засгийн газрын тэргүүн нараас баярын илгээлт ирүүлэв. Мөн НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга, ЮНЕСКО-гийн ерөнхий захирал, Дэлхийн буддын холбооны ерөнхийлөгч, ХШЭТБХ-ын ерөнхийлөгч зэрэг олон улсын болон үндэсний энх тайвны хөдөлгөөн, байгууллага, мөн шашны томоохон зүтгэлтнүүдээс 30 шахам баярын илгээлт их хурлын нэр дээр ирлээ.

Энэ бүхэн нь тус хөдөлгөөн Ази болон дэлхийн энх тайвны үйлсэд хувь нэмрээ оруулж, түүний олон улсын ач холбогдол, нэр хүнд өсч байгааг харуулав.

АБЭТБХ-ын VII Ерөнхий бага хурлаас Вьентьяны тунхаглал, Ерөнхий тогтоол, тусгай тогтоол, Зөвлөлтийн удирдлагын 1986 оны Нэгдүгээр сарын 15-ны мэдэгдлийн талаарх тогтоол, Лаосын буддистуудад илгээх илгээлт гэсэн баримт бичгүүдийг батлан гаргасан юм. Эдгээр баримт бичигт одоогийн Ази дахины буддистуудын энх тайвны тэмцлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийлгээд, Азийн буддистуудын өмнө тулгарч байгаа ээлжит зорилтуудыг тодорхойллоо. Үүнд:

— манай гариг дээрх амьд амьтан бүхний оршин байхуйд заналхийлж байгаа халуун цөмийн дайны аюулыг сэрэмжлэн зайлуулж, зэвсгийн

хуримтлагдсан их нөөцийг эрс хорогдуулан, улмаар зэвсгийг бүхний тээр бүрэн хураахын төлөө улс түмний нийтийн тэмцэлд улам их идэвхтэй, санаачилгатай оролцох,

— Ази тивийн дэвсгэр нутаг, Энэтхэгийн болон Номхон далайн сав газар өнөөгийн бий болоод байгаа хурцадмал байдлыг намжаахын төлөө, цэргийн түрэмгий баазыг устгах, энэ районд цөмийн зэвсэггүй бүс бий болгон өргөтгөхийн төлөө улам их хүчин чармайлт тавих,

— бурхан багшийн энх амгалангийн сургаалыг удирдлага болгон хэрэгжүүлж, энх амгалан аж төрөх хүн бүрийн түгээмэл эрхийн төлөө, энхийн эрхэм үйлсийг өрнүүлэхийн төлөө үйл ажиллагаагаа цаашид идэвхжүүлэн, энэ үйлсэд шашны болон шашны бус үндэсний төвүүд, НҮБ-ийн болон засгийн газрын бус байгууллага, хөдөлгөөнүүдтэй харилцан ойлголцож, хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийг онцлон заалаа.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд АБЭТБХ-ын Удирдах төв болон үндэсний төвүүдээс энх тайванч үйл ажиллагаагаа улам идэвхжүүлэн гүнзгийрүүлж, тэмцлийн олон хэлбэрийг улам баяжуулан ашиглах нь чухал гэж бага хурал үзэв.

Үүний урьд ажиллаж ирсэн Панчашилын зарчмыг сурталчлах, Зэвсэг хураах болон энх тайвны хүмүүжлийн асуудал эрхэлсэн комиссуудын дээр «Энэтхэгийн далай энх тайвны бүс» гэсэн комиссыг шинээр байгуулсан нь Ази тивийн энх тайвны нэн чухал энэ асуудалд АБЭТБХ тусгайлан анхаарал тавьж байгаагийн илрэл боллоо.

АБЭТБХ-ын VII Ерөнхий бага хурал манай тивийн буддистуудын энх тайвны хөдөлгөөний өрнөлт, энх амгалангийн төлөө бурхны шашинтны хамтын тэмцэлд шинэ түлхэц болох нь дамжиггүй. Ерөнхий бага хурлынхаа шийдвэрийг хэрэгжүүлэх явдлыг АБЭТБХ-ын Удирдах төв, үндэсний төвүүдийн үйл ажиллагааны өнөөгийн гол агуулга болгож байна.